



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/17/СТА-ТТЗ

Баянхонгор
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayar_j@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13

1 Аудитын гэрчилгээ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга З.Мөнхтөр-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 15-наас 2019 оны 03 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 29 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шинэжинст сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Шинэжинст сумын Засаг дарга нь “Сумын Засаг даргын Тамгын газар нь мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн төрийн захиргааны байгууллага болж, иргэддээ шударга, шуурхай, ил тод нээлттэй үйлчилнэ.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Шинэжинст сумын Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Баянхонгорын иргэд-Баянхонгорын баялаг” зарчмыг удирдлага болгож, иргэдээ бүх талаар системтэй хөгжүүлнэ.
- Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг эрчимтэй хөгжүүлэн 20-оос доошгүй иргэнийг тогтвортой байнгын ажлын байраар хангаж, ядуурлыг 2 дахин бууруулна.
- Боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, боловсролын чанарын үзүүлэлтийг тэргүүлэх сумуудын хэмжээнд хүргэхийг зорино.
- Хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг багасгаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг олон улсын жишигт нийцүүлэхийг зорьж, дундаж наслалтыг

нэмэгдүүлэх, эрүүл амьдрах таатай боломжийг бүрдүүлсэн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх

- Соёл урлаг, биеийн тамир спорт нь хүний хөгжлийн чухал хүчин зүйл хэмээн үзэж бүх талаар дэмжиж хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх.

Шинэжинст сумын Засаг даргын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Шинэжинст сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	3	3	-	2	-
	Дүн	3	3	-	2	-

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шинэжинст сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шинэжинст сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бүртгэл мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн

системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Шинэжинст сумын Засаг даргын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Шинэжинст сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Шинэжинст сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийжээ. Аудитаар нийт Шинэжинст сумын ИТХ, ЗДТГ, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв нь 2018 оны 1 дүгээр улирлын тайлан илгээгээгүй байсныг хяналт шалгалтын хугацаанд тайланг илгээж зөрчлийг арилгаж ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шинэжинст сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2729091.8 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 27,290.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Шинэжинст сумын Засаг даргын болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 14033.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 5324.8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Засаг даргын тамгын газрын төлбөр хураамжийн зардлаас 330,0 төгрөгийг хоолны зардалд зарцуулсан, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад 774,4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал бодож олгосон байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон

Асуудал : Засаг даргын нөөц хөрөнгөөс 1635.0 мянган төгрөгийн зориулалт бусаар зарцуулсан, ЗДТГ-ын жилийн эцсийн тооллогын бүртгэлээр үндсэн хөрөнгийн дансанд хүний нэрээр орлого авч 5972.1 хөрөнгийн ямар хөрөнгө оршин байгаа нь тодорхойгүй байна.

Шийдэл: Зөвлөмж өгсөн

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал илрээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шинэжинст сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1782779.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1081712.9 мянган төгрөг буюу 90.2 хувьтай байгаа нь 2018 онд улсын төсвөөс 1094269.5 мянга, санхүүгийн дэмжлэгээр 338956.9 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 113708.3 мянган төгрөгийн санхүүжилт авч орон нутгийн төсвөөс 21276.4 мянга, урьд оны үлдэгдлээс 16234.5 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 116388.4 мянган төгрөгийг төсөвт байгууллагын болон орон нутгийн тусгай сангийн урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 174306.4 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 22580.0 мянган төгрөг ба гүйцэтгэлээр 65605.9 мянган төгрөгийн орлого төвлөрч 43025.9 мянган төгрөг буюу 290.5 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнд хадгаламжийн хүүгийн орлого 16637.7 мянган төгрөг, ИОТХуудсаар орсон орлого 4887.7 мянга, Улсын тэмдэгтийн хураамж 826.5 мянга, Бууны татвар 30.0 мянга, Хүү, торгуулийн орлого 3175.0 мянган төгрөгөөр давсан бол нохой албан татвар 298.0 мянган төгрөгөөр тасарсан байна. Харин ҮХЭХ борлуулсны татвар 9289.6 мянга, бусад татвар 2600.0 мянга, ус рашаан ашигласны төлбөр 5477.5 мянга, хог хаягдлын хураамж 400.0 мянган төгрөгөөр төвлөрсөн ба тус орлогуудыг төсөвт оруулахаар төлөвлөн тооцоогүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шинэжинст сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 17 төрлийн 118 мэдээллээс 99 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22 гүйлгээг хугацаанд нь тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Өмнө оны санхүүгийн тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2018 оныг “Санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулах жил” болгон ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй бөгөөд харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 37.9 хувь буюу 5324.8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 7.9 хувь буюу 1101.4 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 54.2 хувь буюу 7607.1 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

№	Байгууллагын ангилал	Мянган төгрөг							
		Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-
2	ТШЗ	6	8708.5	2	5324.8	8	14033.3	2	5324.8
	Дүн	6	8708.5	2	5324.8	8	14033.3	2	5324.8

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил	Мянган төгрөг										
			Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
2	ТШЗ	6	8708.5	2	1101.4	-	-	4	7607.1	-	-	-	
	Дүн	6	8708.5	2	1101.4	-	-	4	7607.1	-	-	-	

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	5	-	-	-	5
	Дүн	5	-	-	-	5

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	412803599.35	542356171.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	90832030.60	209707917.32
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	90832030.60	209707917.32
3121	Төгрөг	90832030.60	209707917.32
31211	Төрийн сангийн харилцах	90832030.60	209707917.32
33	АВЛАГА	126444180.45	58338316.07
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	204574.45	418116.07
335	Бусад авлага	2750000.00	7055000.00
3351	Байгууллагаас авах авлага	2750000.00	7055000.00
336	Зээлийн авлага	123489606.00	50865200.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	123489606.00	50865200.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	123489606.00	50865200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	195527388.30	264309938.29
351	Түүхий эд материал	85160865.00	116543615.00
35110	Тусгай зориулалттай материал	84987115.00	116369865.00
35130	Эм боох материал	173750.00	173750.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	40843000.00	30871000.00
354	Хангамжийн материал	67617523.30	101459323.29
35410	Бичиг хэргийн материал	3102240.00	3062240.00
35420	Аж ахуйн материал	34756859.00	35244159.00
35430	Сэлбэг хэрэгсэл		800000.00
35440	Түлш, шатах тослох материал	216600.41	0.40
35460	Хүнсний материал	82000.00	137600.00
35470	Бусад хангамжийн материал	29459823.89	62215323.89
35600	Мал амьтад	1906000.00	15436000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	10000000.00
36600	Бусад нөөц	0.00	10000000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4903930189.44	6094188552.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4903930189.44	6094188552.15
392	Биет хөрөнгө	4865170189.60	5916130885.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	6091167570.00	6048486544.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	1694201274.57	618777972.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	200095437.00	206203574.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	135592269.20	126411014.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	509822610.14	521691610.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	342392000.13	369927773.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	231224461.95	279429032.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	109920442.55	134131963.91
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2626000.00	4926000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	1120533.23	1637233.19
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1638838.00	1638838.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	119047018.13	119047018.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	29380336.07	38358785.19
39217	Ном	22155110.13	23953010.13
393	Биет бус хөрөнгө	38759999.84	178057666.50
39301	Програм хангамж	2100000.00	2100000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	2100000.00	2100000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	39200000.00	178516000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	440000.16	458333.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5316733788.79	6636544723.83

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	257311.00	469818.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	257311.00	469818.00
413	Өглөг	257311.00	469818.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	196615.00	408018.00
4136	Бусад өглөг	60696.00	61800.00
41361	Байгууллагад төлөх өглөг	60696.00	61800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5316476477.79	6636074905.83
51	Засгийн газрын хувь оролцоо	5316476477.79	6636074905.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2322554372.93	2422292372.93
51101	Өмч: - төрийн	2322554372.93	2422292372.93
512	Хуримтлагдсан үр дүн	2272143032.18	2118498242.97
51210	Өмнөх үеийн үр дүн	2149321302.37	2272143032.18
51220	Тайланг үеийн үр дүн	122821729.81	-153644789.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	721779072.68	2095284289.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5316733788.79	6636544723.83

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2342703679.60	2191197207.02
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20499320.82	31093161.10
110	Орлогын албан татвар	8778528.82	10387491.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	8778528.82	10387491.10
110002	Үйл ажиллагааны орлого	8778528.82	10387491.10
113	Хөрөнгийн албан татвар	2626000.00	10399600.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1400000.00	9289600.00
113002	Бууны албан татвар	1226000.00	1110000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	9094792.00	10306070.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1310130.00	2226570.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1310130.00	1826570.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж		400000.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	7057782.00	5477500.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	7057782.00	5477500.00
1183	Бусад татвар	726880.00	2602000.00
118301	Бусад татвар	556380.00	2600000.00
118304	Нохойны албан татвар	170500.00	2000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	529207214.20	527602026.92
120	Нийтлэг татварын бус орлого	529207214.20	527602026.92
120002	Хүүгийн орлого	6564134.10	30337739.12
120003	Торгуулийн орлого	1485000.00	4175000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	521158080.10	493089287.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39581351.00	1935801.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	49488841.60	43099330.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	432087887.50	448054156.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1792997144.58	1632502019.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1039904430.58	1094269500.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	7116130.58	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1032788300.00	1094269500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31454154.00	42274732.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31454154.00	42274732.00

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	693500800.00	452665200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322285400.00	0.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	298358600.00	338956900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	72856800.00	113708300.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	29700000.00
133003	Хөрөнгийн	0.00	29700000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28137760.00	13592587.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	28137760.00	13592587.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2219881949.79	1880768172.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2214881949.79	1880768172.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1752311308.21	1757217099.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	842974275.82	857956403.49
210101	Үндсэн цалин	752746748.27	743306954.49
210102	Нэмэгдэл	43013279.55	69924800.00
210104	Урамшуулал	31040263.00	42327342.00
210105	Гэрээт ажлын хөлс	16173985.00	2397307.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93859243.03	100149831.97
210201	Тэтгэврийн даатгал	93859243.03	100149831.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84012006.65	155026299.00
210301	Гэрэл, цахилгаан	9569588.00	8197976.00
210302	Түлш, халаалт	72825128.65	145604296.00
210303	Цэвэр, бохир ус	1617290.00	1224027.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60050939.00	51680862.01
210401	Бичиг хэрэг	6086730.00	5761150.00
210402	Тээвэр, шатахуун	39103070.00	39881212.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4368100.00	2760900.00
210404	Ном, хэвлэл	1110900.00	537200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	985700.00	854800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4770339.00	1885600.00
210408	Бараа материал актисны зардал	3626100.00	
2105	Нормативт зардал	101480690.00	103592915.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17830990.00	20358100.60
210502	Хоол, хүнс	83649700.00	79448515.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		3786300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11347700.00	5730900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1329800.00	149000.00
210604	Урсгал засвар	10017900.00	5581900.00
2107	Томилолт, зочны зардал	10447400.00	9383490.00
210702	Дотоод албан томилолт	10447400.00	9383490.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44227898.00	23191608.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43144140.00	22137015.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250000.00	124800.00
210803	Даатгалын үйлчилгээ	735450.00	453000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	292000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	60305.00
210807	Газрын төлбөр	62488.00	62488.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	35820.00	62000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	503911155.71	450504789.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	209269551.47	162762042.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1089850.00	2962000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	293551754.24	284780747.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	462570641.58	123551072.82
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	34200000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		34200000.00

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	128818671.00	86575899.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	28137760.00	13592587.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5011700.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31655050.00	20646460.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		20689000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33753496.00	29667852.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30260665.00	1980000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	330111210.58	0.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	322285400.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7825810.58	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3640760.00	2775173.82
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3640760.00	2775173.82
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5000000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5000000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	5000000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	122821729.81	310429034.24
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	464073823.45
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	33891427.66
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		58040500.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		372079395.79
230001	Эргэж төлөгдөх зээл		62500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-464073823.45
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	122821729.81	-153644789.21

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1910615792.10	1784796364.22
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20499320.82	31093161.10
110	Орлогын албан татвар	8778528.82	10387491.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	8778528.82	10387491.10
110002	Үйл ажиллагааны орлого	8778528.82	10387491.10
113	Хөрөнгийн албан татвар	2626000.00	10399600.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1400000.00	9289600.00
113002	Бууны албан татвар	1226000.00	1110000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	9094792.00	10306070.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1310130.00	2226570.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1310130.00	1826570.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж		400000.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	7057782.00	5477500.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	7057782.00	5477500.00
1183	Бусад татвар	726880.00	2602000.00
118301	Бусад татвар	556380.00	2600000.00
118304	Нохойны албан татвар	170500.00	2000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97119326.70	150901184.12
120	Нийтлэг татварын бус орлого	97119326.70	150901184.12
120002	Хүүгийн орлого	6564134.10	30337739.12
120003	Торгуулийн орлого	1485000.00	4175000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89070192.60	116388445.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39581351.00	73289115.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	49488841.60	43099330.00

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1792997144.58	1602802019.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1039904430.58	1094269500.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	7116130.58	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1032788300.00	1094269500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31454154.00	42274732.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31454154.00	42274732.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	693500800.00	452665200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322285400.00	0.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	298358600.00	338956900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	72856800.00	113708300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28137760.00	13592587.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	28137760.00	13592587.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1756181131.60	1493586375.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1756181131.60	1493586375.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1293015490.02	1359971402.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	840018209.43	860399061.67
210101	Үндсэн цалин	719882062.43	719094524.67
210102	Нэмэгдэл	37353800.00	74761598.00
210104	Урамшуулал	44813483.00	41911332.00
210105	Гэрээт ажлын хөлс	37968864.00	24631607.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93351919.00	97748908.41
210201	Тэтгэврийн даатгал	93351919.00	82369605.00
210202	Тэтгэмжийн даатгал		4153654.36
210203	ҮОМШӨ-ний даатгал		2944089.00
210204	Ажилгүйдлийн даатгал		475249.00
210205	Эрүүл мэндийн даатгал		7806311.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74385026.00	155197596.00
210301	Гэрэл, цахилгаан	8853816.00	8150873.00
210302	Түлш, халаалт	63598200.00	145387696.00
210303	Цэвэр, бохир ус	1933010.00	1659027.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52907610.00	50805222.00
210401	Бичиг хэрэг	5743080.00	5201150.00
210402	Тээвэр, шатахуун	38268280.00	38695522.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3806500.00	3029000.00
210404	Ном, хэвлэл	1212750.00	537200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1326000.00	1496050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2551000.00	1846300.00
2105	Нормативт зардал	114332830.00	104139515.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17776740.00	20358100.60
210502	Хоол, хүнс	83630390.00	79395115.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12925700.00	4386300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13976600.00	8036900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2908700.00	1629000.00
210604	Урсгал засвар	11067900.00	6407900.00
2107	Томилолт, зочны зардал	10426300.00	9383490.00
210702	Дотоод албан томилолт	10426300.00	9383490.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52887493.00	40044129.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51803735.00	38956186.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250000.00	124800.00
210803	Даатгалын үйлчилгээ	705450.00	453000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		292000.00

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30000.00	60305.00
210807	Газрын төлбөр	62488.00	62488.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	35820.00	95350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40729502.59	34216580.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36035152.59	20687100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4694350.00	13529480.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	463165641.58	133614972.82
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	44200000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	44200000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	129413671.00	86639799.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	28137760.00	11086870.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		2505717.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5011700.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31655050.00	20710360.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		20689000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшигтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33753496.00	29667852.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30855665.00	1980000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	330111210.58	1194930.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	322285400.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7825810.58	1194930.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3640760.00	1580243.82
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3640760.00	1580243.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	154434660.50	291209988.72
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	124014964.00	172334102.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	124014964.00	172334102.00
2200	Дотоод эх үүсвэрээр	124014964.00	172334102.00
223001	Бусад хөрөнгө	117295664.00	144197902.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6719300.00	28136200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-124014964.00	-172334102.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	30419696.50	118875886.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60412334.10	90832030.60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	90832030.60	209707917.32

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,322,554,372.93	721,779,072.68	2,148,988,969.31	5,193,322,414.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			332,333.06	332,333.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,322,554,372.93	721,779,072.68	2,149,321,302.37	5,193,654,747.98
Тайланг үеийн үр дүн			122,821,729.81	122,821,729.81
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,322,554,372.93	721,779,072.68	2,272,143,032.18	5,316,476,477.79
2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,322,554,372.93	721,779,072.68	2,272,143,032.18	5,316,476,477.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,322,554,372.93	721,779,072.68	2,272,143,032.18	5,316,476,477.79
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		1,373,505,217.25		1,373,505,217.25
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	99,738,000.00			99,738,000.00
Тайланг үеийн үр дүн			-153,644,789.21	-153,644,789.21
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,422,292,372.93	2,095,284,289.93	2,118,498,242.97	6,636,074,905.83

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1587217100.00	1474077118.84	1782779285.50	1608472914.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1451572500.00	1356781454.84	1629070985.50	1464275012.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1353239300.00	1258616639.84	1505396985.50	1341316152.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	843427900.00	839811933.43	862966200.00	858330661.67
210101	Үндсэн цалин	723532000.00	719675786.43	726619900.00	717026124.67
210102	Нэмэгдэл	37353800.00	37353800.00	69924800.00	74761598.00
210104	Урамшуулал	44523700.00	44813483.00	41956300.00	41911332.00
210105	Гэрээт ажлын хөлс	38018400.00	37968864.00	24465200.00	24631607.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94164100.00	93351919.00	100269500.00	97748908.41
210201	Тэтгэврийн даатгал	60009200.00	93351919.00	72597500.00	82369605.00
210202	Тэтгэмжийн даатгал	6883300.00		6925300.00	4153654.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	8486300.00		5540600.00	2944089.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1707800.00		1355100.00	475249.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17077500.00		13851000.00	7806311.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75943400.00	74385026.00	156573700.00	155197596.00
210301	Гэрэл, цахилгаан	10353800.00	8853816.00	9463500.00	8150873.00
210302	Түлш, халаалт	63627600.00	63598200.00	145448200.00	145387696.00
210303	Цэвэр, бохир ус	1962000.00	1933010.00	1662000.00	1659027.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54504800.00	53651610.00	53144200.00	52593122.00
210401	Бичиг хэрэг	5490400.00	5497480.00	5207100.00	5201150.00
210402	Тээвэр, шатахуун	38239300.00	38050780.00	39060800.00	38695522.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	4341600.00	3806500.00	3072200.00	3029000.00
210404	Ном, хэвлэл	2542100.00	2419850.00	2382900.00	2325100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1328000.00	1326000.00	1399400.00	1496050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2563400.00	2551000.00	2021800.00	1846300.00
2105	Нормативт зардал	114463700.00	114332830.00	104213400.00	104139515.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17775400.00	17776740.00	20477000.00	20358100.60
210502	Хоол, хүнс	83703600.00	83630390.00	79405600.00	79395115.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12984700.00	12925700.00	4330800.00	4386300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14818800.00	14642400.00	9819400.00	10336900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2915200.00	2908700.00	1629800.00	1629000.00
210602	Тавилга			2300000.00	2300000.00
210604	Урсгал засвар	11903600.00	11733700.00	5889600.00	6407900.00
2107	Томилголт, зочны зардал	10665900.00	10426300.00	10205500.00	9383490.00
210702	Дотоод албан томилолт	10665900.00	10426300.00	10205500.00	9383490.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31451300.00	29807644.00	17834185.50	17695379.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	29839300.00	28723886.00	16315685.50	16607436.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250000.00	250000.00	250000.00	124800.00
210803	Даатгалын үйлчилгээ	900000.00	705450.00	500000.00	453000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193500.00		350000.00	292000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30000.00	30000.00	200000.00	60305.00
210807	Газрын төлбөр	90000.00	62488.00	70000.00	62488.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148500.00	35820.00	148500.00	95350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113799400.00	28206977.41	190370900.00	35890580.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109081600.00	23512627.41	175746400.00	22317100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4717800.00	4694350.00	14624500.00	13573480.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98333200.00	98164815.00	123674000.00	122958860.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00	67254300.00	66654300.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг			67254300.00	66654300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	98333200.00	98164815.00	56419700.00	56304560.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5011700.0	5011700.0		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31737300.0	31655050.0	20825100.00	20710360.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			20689000.00	20689000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30642400.0	30642400.0	14005200.00	14005200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30941800.0	30855665.0	900400.00	900000.00

Шинэжинст сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	135644600.0	117295664.0	153708300.0	144197902.0
2200	Дотоод эх үүсвэрээр	135644600.0	117295664.0	153708300.0	144197902.0
223001	Бусад хөрөнгө	135644600.0	117295664.0	153708300.0	144197902.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1587217100.00	1493028599.84	1782779285.50	1691471927.68
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1032788300.00	1029147540.00	1094886500.00	1092689256.18
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1032788300.0	1029147540.0	1094886500.00	1092689256.18
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	415845400.00	388026069.42	475245200.00	482394226.50
132001	Орон нутгийн төсвөөс	342988600.0	315169269.4	361536900.00	368685926.50
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	72856800.0	72856800.0	113708300.00	113708300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	138583400.00	75854990.42	212647585.50	116388445.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000000.00	39375075.00	155813000.00	73289115.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41100000.00	36479915.42	40600000.00	43099330.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	95483400.0		16234585.50	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		55915534.1		74597445.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		74597445.1		157596458.10
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5.00	5.00	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	5.0	5.0	6.00	6.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	117.00	121.00	106.00	104.00
620001	Удирдах ажилтан	12.0	13.0	12.00	12.00
620002	Гүйцэтгэх ажилтан	62.0	63.0	60.00	63.00
620003	Үйлчлэх ажилтан	27.0	29.0	32.00	27.00
620004	Гэрээт ажилтан	16.0	16.0	2.00	2.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	606.00	590.00	494.00	508.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	478.00	470.00	374.00	388.00
630001	Төрийн өмчит ЕБС	478.0	470.0	374.00	388.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	128.00	120.00	120.00	120.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	128.0	120.0	120.00	120.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	117.0	121.0	106.0	104.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.0	8.0	9.00	9.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	34.0	34.0	34.00	36.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	3.0	3.0	3.00	4.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17.0	18.0	17.00	17.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30.0	35.0	34.00	29.00
650010	Гэрээт ажилтан	16.0	16.0	2.00	2.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.0	7.0	7.00	7.00